



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/104

Чойр

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 5.4.2 дах зүйлийн 5.4.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Харчин овогт Цэенхорлоогийн Төрмөнх нь (Ч375021718) Сүмбэр сумын 1 дүгээр багт Төмөр замын 133 дугаар байрны ар талд байрлах гараашийн зориулалттай 30м² газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул Хиад овогт Сосорбурамын Энхтөгсгуад (ЕЙ70082205) Сүмбэр сумын 1 дүгээр багт Замчдын гудамж 1-Г/7 тоотод байрлах 30м² газрыг гараашийн зориулалтаар эзэмших эрхийг анх авсан этгээдийн үлдсэн хугацаагаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Хуулийн дагуу эзэмшилдээ авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг иргэн (С.Энхтөгсгуа)-д үүрэг болгосугай.


3.Газар эзэмшигч иргэн С.Энхтөгсгуад эзэмшил газрын кадастрын ажил гүйцэтгүүлэх хуудас болон газар эзэмших гэрээ, гэрчилгээг цахимаар үүсгэж, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Отгончимэг)-д зөвшөөрсүгэй.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2013 оны А/310 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ



Аймгийн Засаг даргын 2024 оны
01... сарын 02...-ны өдрийн 1/01 дугаар
захирамжийн хавсралт



Хиад овогт Сосорбурамын Энхтөгсугагийн эзэмшилд
шилжүүлж байгаа газрын байршлын зураг

| Сумын нэр | Багийн дугаар | Газрын хэмжээ /м ² / | Эзэмших хугацаа /жил/ | Газрын зориулалт | Газрын байршил, нэр |
|-----------|---------------|---------------------------------|-----------------------|------------------|----------------------|
| Сүмбэр | 1 | 30 | 5 | Гарааш | Замчдын гудамж 1-Г/7 |

